



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Хүсэлтээ хэлэлцүүлэлгүйгээр
буцаан авах хүсэлтийг шийдвэрлэсэн тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн, шүүгч Г.Алтанчимэг, Ч.Хосбаяр, Ч.Тунгалаг, шүүгч Б.Амарбаясгалан, С.Батдэлгэр, Г.Банзрагч, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, П.Золзаяа, Б.Мөнхтуяа, Д.Мөнхтуяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Д.Цолмон, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар Ардчилсан намын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Ган-Очирын 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 03/34 дугаартай албан бичгээр “Ардчилсан намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг бүртгүүлэх” тухай хүсэлтийг хэлэлцэхтэй холбогдуулан Б.Ган-Очир, П.Нүрзэд нараас нийт шүүгчийн хуралдаанд хандан 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 02/116 дугаартай албан бичгээр хүсэлт ирүүлснийг хүлээн авч, илтгэгч Захиргааны хэргийн танхимын тэргүүн Ч.Тунгалагийн танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Б.Ган-Очир, П.Нүрзэд нар ирүүлсэн хүсэлтдээ: “Ардчилсан намын Улс төрийн зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 08/01 тоот тогтоолд Ардчилсан намын бүртгэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх тухай 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 03/43 тоот хүсэлт, тус хүсэлтийн хавсралтаар хүргүүлсэн 55 боть, 9000 гаруй хуудас материалуудыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэлгүйгээр эргүүлэн авахаар шийдвэрлэсэн болно. Иймд дээрх материалыг хүлээлгэн өгнө үү” гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхэд Ардчилсан намын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Ган-Очироос 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 03/34 дугаартай албан бичгээр “Ардчилсан намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг бүртгүүлэх”-ээр хүсэлт гаргаж, уг хүсэлтэд 55 хавтас материал, нэг ширхэг сиди хавсаргаж 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр ирүүлснийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 09 дүгээр тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын дагуу Намын бүртгэл хөтлөхтэй холбогдох ажиллагааг хийж, гүйцэтгэн, Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхийг хүссэн Ардчилсан намын өргөдлийг хэлэлцэх нийт шүүгчийн хуралдааныг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2022 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 30 дугаар захирамжаар 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 14 цаг 30 минутад хэлэлцэхээр товлон зарласан.

Ардчилсан намын ээлжит бус Их хурлын 2022 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 10 дугаар тогтоолын хоёр дахь заалтаар Улсын дээд шүүхэд Ардчилсан намын даргыг болон холбогдох баримт бичигт оруулах өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх, захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцох, бүртгэлтэй холбоотой бүхий л асуудлаар Ардчилсан намыг төлөөлөх бүрэн эрх олгогдсон Б.Ган-Очир, П.Нүрзэд нар нь “Ардчилсан намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэх”-ээр гаргасан хүсэлтээ нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж, холбогдох материалуудаа буцаан авахыг хүссэн байна.

Иймд, Ардчилсан намын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Ган-Очир, П.Нүрзэд нарын 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 02/116 дугаартай албан бичгээр гаргасан хүсэлтийг хангаж, “Ардчилсан намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэх” тухай хүсэлт гаргаагүйд тооцож, 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 03/34 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлт, түүнд хавсаргасан материалыг хүсэлт гаргагчид буцаах нь зүйтэй гэж нийт шүүгчийн хуралдаанаас дүгнэлээ.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Ардчилсан намын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Ган-Очир, П.Нүрзэд нарын хүсэлтийг хангаж, “Ардчилсан намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэх” тухай хүсэлт гаргаагүйд тооцож, “Ардчилсан намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг бүртгүүлэх”-ээр ирүүлсэн хүсэлт, 55 хавтас материал, нэг ширхэг сиди-г буцаасугай.

2.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д зааснаар улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 төгрөгийг хүсэлт гаргагчид буцаан олгосугай.

ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ,
ТАНХИМЫН ТЭРГҮҮН

Ч.ТУНГАЛАГ